



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН
ЗАРДЛЫГ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛАН ЗОРИУЛАЛТЫН
ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ ХИЙХ.

АУДИТЫН КОД: УВА-2026/99-ШТА-НА

Улаангом хот 2026 он

Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг: batsuurm@audit.gov.mn

Аудитын менежер М.Бат-Амгалан

Утас: 70453317 Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Авирмэд

Цахим хаяг: avirmedb@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokhch@audit.gov.mn

Аудитор А.Нанжидмаа

Цахим хаяг: nanjidmaaa@audit.gov.mn

Аудитор Т.Золлоо

Цахим хаяг: zoloot@audit.gov.mn

Аудитор Т.Ариунсайхан

Цахим хаяг: ariunsaikhannt@audit.gov.mn

Аудитор Б.Нямбуу

Цахим хаяг: nyambuub@audit.gov.mn



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/29

Улаангом

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/32 дугаар “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудитын тайланг (УВА-2026/99-ШТА-НА) хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор Ч.Мөнхтогтох нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

8525010087

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор	Товчилсон үгийн тайлал	4
М.Батсуурь	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6
Аудитын менежер	Бүлэг 1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.	7
М.Бат-Амгалан	1.1. Сонгуулийн хороонд зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.	7-8
Ахлах аудитор	1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой холбогдох төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.	8-9
Б.Авирмэд	Бүлэг 2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж 2,224.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	9
Ч.Мөнхтогтох	2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 2,224.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	9-10
Аудитор	2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.	10
Т.Золоо	2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.	11
А.Нанжидмаа	Дүгнэлт	12
Б.Нямбуу	Холбогдох байгууллагын санал	13
Т.Ариунсайхан	Аудитын газраас өгөх тайлбар	
2026 оны 07 дугаар сар		
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317 дугаарын утсаар харилцана уу.		
Хаяг:		
Увс аймаг дахь Төрийн Аудитын газар		
Улаангом сум 3 баг		
аймгийн Засаг даргын тамгын газрын байр		

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ:

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГНАГ	Гүйцэтгэл нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
МТБ	Мэдээлэл технологийн баг

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10, 10.11 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2026 оны А/32 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгох санхүүжилтийг зөв төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт, гүйцэтгэлийг зөв тайлагнасан эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад аймгийн Сонгуулийн хороо, Увс аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Баруунтуруун, Бөхмөрөн, Завхан, Наранбулаг, Хяргас, Улаангом сумдын сонгуулийн хорооны баримт материалыг хамруулан хийж гүйцэтгэлээ.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх зэрэг арга зүйг ашигласан.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Б.Авирмэд, Ч.Мөнхтогтох, аудитор Т.Золоо, А.Нанжидмаа, Т.Ариунсайхан, Б.Нямбуу нар гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2026 оны нөхөн сонгуулийг аймгийн Сонгуулийн хороо, 6 сумын Сонгуулийн хороо, 8 Хэсгийн хороо аймгийн ИТХ-ын 2 суудал, сумын ИТХ-ын 4 суудалд зохион байгуулсан байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой аймгийн Сонгуулийн хороонд 168,090.5 мянган төгрөгийн төсөв олгосон байна.

БҮЛЭГ: 1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.

1.1. Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/33 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1-д “Сонгуулийн ерөнхий хороо нь тухайн сонгуулийн хуульд заасан ангиллын дагуу өрхийн тоо, сонсогчийн тоо, сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороон бүрээр тухайн сонгуулийн батлагдсан төсөвт багтаан хуваарилна” гэж заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 3/354 дүгээр тушаалаар аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуулийн санхүүжилтийн хуваарийг гаргаж Увс аймгийн Сонгуулийн хороонд 168,090.5 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.

Журмын 2.2-д “Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардал хуваарилна” гэж заасны дагуу дараах байдлаар хуваарилж ирүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт-1

		/мян.төг/
№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх	303.00
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	1,275.00
3	Бичиг хэрэг	2,400.00
4	Шуудан холбоо	2,800.00
5	Унаа	8,320.00
6	Санал авах байр бэлтгэх	2,400.00
7	Сурталчилгаа	5,600.00
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа, томилолт	17,004.00
9	МТБ-ийн холбоо, унааны зардал	480.00
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах	560.00
11	Томилолтын зардал	7,432.00
12	Шуурхай баг	1,720.00
13	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол	101,497.50
14	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	16,299.00
	ДҮН	168,090.50

/Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын тушаал/

Журмын 2.3-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар, аргачлал, байгуулагдсан сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоо, хол ойрын зай байршлыг

харгалзан сум, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах байдлаар хуваарилна” гэж заасны дагуу Увс аймгийн Сонгуулийн хорооны даргын “Санхүүжилт хуваарилах тухай” 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/02, 06 дугаар сарын 09-ний өдрийн А/03, 06 дугаар сарын 12-ны өдрийн А/04 дугаар захирамжаар сонгууль зохион байгуулах санхүүжилтийг тус тус хуваарилсан байна.

Үүнд:

Хүснэгт-2

/мян.төг/

№	Зардлын нэр	Аймгийн төв	Улаангом	Бөхмөрөн	Наранбулаг	Завхан	Баруунтуруун	Хяргас	Нийт
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	63.0	40.0	40.0	40.0	40.0	40.0	40.0	303.0
2	Сургалтын зардал	1,275.0							1,275.0
3	Бичиг хэрэг	400.0	300.0	500.0	300.0	300.0	300.0	300.0	2,400.0
4	Шуудан холбоо	800.0	300.0	500.0	300.0	300.0	300.0	300.0	2,800.0
5	Унааны зардал	1,240.0	600.0	2,320.0	1,040.0	1,040.0	1,040.0	1,040.0	8,320.0
6	Санал авах байр бэлтгэх зардал		300.0	900.0	300.0	300.0	300.0	300.0	2,400.0
7	Сурталчилгааны зардал	700.0	700.0	1,400.0	700.0	700.0	700.0	700.0	5,600.0
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	15,025.4		434.0	288.8	434.0	434.0	387.8	17,004.0
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	480.0							480.0
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх			140.0	140.0		140.0	140.0	560.0
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	18,627.2	11,159.7	25,146.2	11,159.7	11,159.7	11,159.7	13,157.8	101,569.9
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	2,240.0	1,998.1	3,996.2	1,998.1	1,998.1	1,998.1	1,998.0	16,226.5
13	Томилолтын зардал	4,460.0	-	628.0	484.0	628.0	628.0	604.0	7,432.0
14	Шуурхай багийн зардал	1,720.0							1,720.0
	ДҮН	47,030.6	15,397.8	36,004.4	16,750.6	16,899.8	17,039.8	18,967.6	168,090.5

Дээрх зардлыг хуваарилахдаа Сонгуулийн ерөнхий хорооны 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 3/287, 05 дугаар сарын 25-ны өдрийн 3/311, 06 дугаар сарын 10-ны өдрийн 3/354 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Аймаг нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар”-ыг үндэслэсэн байна.

1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой төрийн захиргааны байгууллага төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

10.2.1.сонгогчийг бүртгэх, түүнийг таньж оруулах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, тээвэрлэх, даатгал хийлгэх зардал, лицензийн төлбөр;

10.2.2.сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, түүнийг цахим хуудаст байршуулах, хэвлэх, хүргэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;

10.2.3.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, холбоо, унаа, томилолтын зардал;

10.2.4.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны сургалт зохион байгуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;

10.2.5.сонгогчийг бүртгэх техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын ажилтны томилолт, унааны зардал, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий мэдээллийн технологийн шуурхай багийн ажилтны мөнгөн урамшуулал, хоолны зардал;
 10.2.6.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;
 10.2.7.сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал.

Дээрх заалтын дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/106 дугаар тушаалаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төсөв”-ийг баталсан байна. Үүнд:

Хүснэгт-3

		/мян.төг/
№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал	7,128.0
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардал	164.5
3	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардал	1,540.0
4	Сонгогчдын бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал	3,300.0
	ДҮН	12,132.5

/Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал/

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байна. Үүнд:

10.3.1.саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хамгаалах, хүргүүлэх үеийн хамгаалалт, санал авах байр болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагар санал авах, дүн дамжуулах үеийн хамгаалалт, техник хэрэгсэл, шатахууны зардал;
 10.3.2.цагдаагийн алба хаагчийн томилолт, унаа, мөнгөн урамшуулал, хоолны зардал.

Дээрх заалтын дагуу Цагдаагийн ерөнхий газрын санхүү, ар талын албаны 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 19/1950 дугаар албан бичгээр “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуулийн хамгаалалтын зардлын төсөв”-ийг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас ирүүлсэн нөхөн сонгуулийн хамгаалалтад ажиллах хүн, хүчний тооцооллыг үндэслэн хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт-4

		/мян.төг/
№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Хоол	10,920.0
2	Дотоод албан томилолт	780.0
3	Шатахуун	7,560.0
	ДҮН	19,260.0

/Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын албан бичиг/

БҮЛЭГ: 2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 2,224.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 2,224.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороодод хуваарилсан төсвийн зарцуулалтыг зардлын зүйл ангиллаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-5

/мян. төг/

№	Зардлын нэр	Аймгийн нийт дүнгээр		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	303.0	285.0	18.0
2	Сургалтын зардал	1,275.0	1,275.0	-
3	Бичиг хэрэг	2,400.0	2,400.0	-
4	Шуудан холбоо	2,800.0	2,800.0	-
5	Унааны зардал	8,320.0	8,078.2	241.8
6	Санал авах байр бэлтгэх зардал	2,400.0	2,400.0	-
7	Сурталчилгааны зардал	5,600.0	5,600.0	-
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	17,004.0	15,557.2	1,446.8
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	480.0	480.0	-
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	560.0	560.0	-
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	101,497.5	101,497.1	0.4
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	16,299.0	16,299.0	-
13	Томилолтын зардал	7,432.0	7,274.7	157.4
14	Шуурхай багийн зардал	1,720.0	1,360.0	360.0
15	Сум төвлөрүүлэх орлого	-	498.2	(498.2)
16	Аймаг төвлөрүүлэх орлого	-	1,726.1	(1,726.1)
	ДҮН	168,090.5	168,090.5	0.0

/Эх сурвалж: Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн сонгуулийн хороонд 168,090.5 мянган төгрөг хуваарилснаас, гүйцэтгэлээр 165,866.2 мянган төгрөг зарцуулж, 2,224.3 мянган төгрөгийн сонгуулийн ерөнхий хорооны дансанд төвлөрүүлсэн байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэгт "Суутган төлөгч нь албан татвар төлөгчид энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ тус

хэсэгт заасан албан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, сар бүр эдлүүлнэ” гэж заасан байна.

Сонгуулийн хороо, хэсгийн хорооны гишүүд, техникийн даамалд урамшуулал, хоолны зардлаас үзүүлсэн татварын хөнгөлөлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-6		/мян.төг/		
№	Сумын нэр	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	Хүний тоо	Татварын хөнгөлөлт
1	Аймгийн төв	20,867.2	18	324.0
2	Бөхмөрөн	29,142.4	29	522.0
3	Наранбулаг	13,157.8	13	234.0
4	Завхан	13,157.8	13	234.0
5	Баруунтуруун	13,157.8	13	234.0
6	Хяргас	15,155.8	15	270.0
Нийт дүн		104,638.7	101	1,818.0

/Эх сурвалж: Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

Аймаг, Хяргас, Наранбулаг, Баруунтуруун, Завхан, Бөхмөрөн сумын сонгуулийн хороо нь хорооны гишүүд, хэсгийн хорооны гишүүд, техникийн даамал нийт 101 хүнд 104,638.7 мянган төгрөгийн урамшуулал, хоолны зардал олгохдоо хувь хүний орлогын албан татварын 1,818.0 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

Аудитын явцад татварын хөнгөлөлт үзүүлсэн 1,818.0 мянган төгрөгийг орон нутгийн татварын дансанд төвлөрүүлж залруулга хийлгэлээ.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар 12,132.5 мянган төгрөгийг итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унаа, сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх, түүнийг хүргэх тээврийн зардал, сонгогчийг бүртгэх, сонгууль зохион байгуулахдаа холбогдон гарах бусад зардалд захиран зарцуулах эрхийг Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсныг дараах байдлаар зарцуулсан байна.

Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын гүйцэтгэл

Хүснэгт-7		/мян.төг/		
№	Зардал	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны урамшуулал	7,278.0	7,278.0	
2	Бичиг хэрэг	164.5	164.5	
3	Томилолт	2,490.0	2,420.0	70.0
4	Тээвэр шатахуун	2,200.0	2,268.3	(68.3)
Нийт дүн		12,132.5	12,130.8	1.7

/Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн баримт/

Хүснэгтээс харахад Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдсан 12,132.5 мянган төгрөгийн зардлаас итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны урамшуулалд 7,278.0 мянга, бичиг хэргийн зардалд 164.5 мянга, томилолтын зардалд 2,420.0 мянга, тээвэр шатахууны зардалд 2,268.3 мянга, нийт

12,310.8 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 1.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2026 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 19/1950 дугаар тушаалаар 19,260.0 мянган төгрөгийг санал авах байрны хамгаалалт, дотоод албан томилолт, тээвэр шатахуун, цагдаагийн албан хаагчийн хоолны зардалд захиран зарцуулах эрхийг Увс аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн байна. Хуваарилсан зардлыг батлагдсан төсвийн дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах байрны хамгаалалтад ажилласан 24, саналын хуудас, санал авах төхөөрөмж хадгалах байрны хамгаалалтад ажилласан 13, битүүмжилсэн хайрцгаар санал авах үеийн хамгаалалтад 8, гэмт хэрэг, зөрчил шалгах ажлын хэсэгт 14, сонгуулийн үйл ажиллагааны үед эргүүлд 16, шуурхай удирдлагын штабт 5, нийт 80 албан хаагчдын хоол, унааны зардалд зарцуулсан байна.

Цагдаагийн газрын зардлын гүйцэтгэл

Хүснэгт-8

Д/д	Зардал	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Хоол	10,920.0	10,920.0	-
2	Шатахуун	7,560.0	2,184.0	5,376.0
3	Томилолт	780.0	-	780.0
	Нийт дүн	19,260.0	13,104.0	6,156.0

/Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал,
Увс аймгийн Цагдаагийн газрын санхүүгийн баримт/

Гүйцэтгэлээр хоолны зардалд 10,920.0 мянга, шатахууны зардалд 2,184.0 мянга, нийт 13,104.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 6,156.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/33 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.4-д “Сум, дүүргийн сонгуулийн хорооны болон салбар комиссын дарга, нягтлан бодогч нар 4.3-т заасан тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын дарга, нягтлан бодогч нар энэ журмын 4.3-т заасан тайланг нэгтгэн 4.2-т заасны дагуу нэгдсэн тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж Сонгуулийн ерөнхий хороонд тус тус хүлээлгэн өгнө”, 4.5-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэгдсэн тайланг аймаг, нийслэлийн аудитын байгууллагаар хянуулан дүгнэлт гаргуулсан байна” гэж заасан байна.

Сонгуулийн хорооны ирүүлсэн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-9

Д/д	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Баруунтуруун	17,039.8	17,039.8	0.0
2	Бөхмөрөн	36,004.4	36,004.4	0.0
3	Завхан	16,899.8	16,419.6	480.2
4	Наранбулаг	16,750.5	16,750.5	0.0
5	Хяргас	18,967.6	18,949.6	18.0

6	Улаангом	15,397.8	15,397.8	0.0
7	Аймаг	47,030.6	45,304.5	1,726.1
	Нийт дүн	168,090.5	165,866.2	2,224.3

Эх сурвалж: /Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.9-д “Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо 1,726.1 мянга, Завхан сумын Сонгуулийн хороо 480.2 мянга, Хяргас сумын Сонгуулийн хороо 18.0 мянга, нийт 2,224.3 мянган төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд төвлөрүүлсэн байна.

2.3. Сонгуулийн зардлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг сонгуулийн зардлын санхүүжилт олгох бүрд дараах албан бичгүүдээр ирүүлсэн байна. Үүнд:

- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 3/287
- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2026 оны 05 дүгээр сарын 25-ны өдрийн 3/311
- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2026 оны 06 дүгээр сарын 10-ны өдрийн 3/354 дүгээр албан бичиг

Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг сонгуулийн зардлын санхүүжилт олгох бүрд дараах албан бичгүүдээр хүргүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/02 дугаар захирамж
- Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/03 дугаар захирамж
- Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/04 дүгээр захирамж

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/33 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 5.1-д Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн зардлын тайланг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс тус бүрээр хянан хүлээн авч нэгтгэн сонгуулийн зардлын гүйцэтгэлийн нэгдсэн тайлан гаргана гэж заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо нь сумын Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын гүйцэтгэлд хяналт тавьж сумын сонгуулийн зардлын тайлан, анхан шатны баримтыг аймгаас хуваарилсан зардлын нэгтгэлтэй тулган 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээж авсан байна.



Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.
2. Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг журмын дагуу зарцуулсан байна.
3. Зардлын гүйцэтгэлийг журамд заасны дагуу тайлагнасан байна.

Холбогдох байгууллагын санал

**УВС АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2214, Факс: 7045-2113

Цахим шуудан: info@khural.uv.gov.mn

Цахим хуудас: www.uvs.khural.mn

2026.07.08 № 16

танай _____ -ны № _____ -т

**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.БАТСУУРЬ ТАНАА**

“Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.

ДАРГА  Ч.ЭНХБАЯР

Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар

Увс аймгийн Сонгуулийн хорооны даргын 2026 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 16 дугаар албан бичгээр тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно гэж хариу ирүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

АУДИТОР:

Б.Авирмэд
Ч.Мөнхтогтох
Т.Золоо
А.Нанжидмаа
Т.Ариунсайхан
Б.Нямбуу

Б.АВИРМЭД
Ч.МӨНХТОГТОХ
Т.ЗОЛОО
А.НАНЖИДМАА
Т.АРИУНСАЙХАН
Б.НЯМБУУ

ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



М.БАТ-АМГАЛАН